# ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ДЭНДЭВИЙН ГАНПҮРЭВИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлтийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | | | |
| 1. | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажилллагааг мэргэжлийн удирдлагаар хангасан байдал | Мэргэжлийн удирдлагаар хангасан арга хэмжээний тоо<br>Хийсэн ажлын тоо, Сонгогдсон боомтуудын чадавхын үнэлгээний тайлан | Ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг гаалийн хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалт хийх ажлыг өдөр тутмын удирдлагаар ханган, Сэлэнгэ, Дархан-Уул, Орхон гаалийн газрын үйл ажиллагаанд үүссэн асуудалд тухай бүр улсын байцаагчийг мэргэжлийн арга зүйгээр ханган ажилласан.<br>Харьяа гаалийн газар хороодын “Бэлэн байдлын төлөвлөгөө”-ний төслийг боловсруулах ажлын хэсэгт холбогдох хуульд заасан заалтын хүрээнд хариу арга хэмжээг хэрхэн авах тухай саналыг боловсруулан хэлтсийн гаалийн улсын | 1.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал /хүний хөл хориот өвчин, мал, амьтны гоц халдварт өвчин, ургамлын хорио цээртэй зүйлс, химийн болон цацрагийн осол, хордлого, хүнсний аюулгүй байдлын өөрчлөлт /-аас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааны талаар харьяа гаалийн газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар тухай бүр хангаж ажиллана. | 1.Улсын хилээр мал, амьтны халдварт өвчин хил дамжин тархахаас урьдчилан сэргийлэх, мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд өвчний сэжиг илэрсэн нөхцөлд хорио цээрийн арга хэмжээ авах, таслан зогсоох, Олон улсын гэрээ хэлэлцээр, протокол, Монгол улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үндсэн зорилтын хүрээнд харъяа гаалийн газрын 19 хилийн боомтын мал эмнэлгийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагчдыг мэргэжил арга зүйгээр бодлогын түвшинд ханган ажиллаж байна.<br><br>-2024 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Замын-Үүд боомтоор “Эм И Ай Эл интернэйшнл” ХХК-ний Энэтхэг Улсаас импортлогдсон 75 тн цагаан будаанд гадаад хорио цээртэй Гурилын жижиг жуулгавч, Суринамын гурилч цох илэрсэн тул холбогдох хууль, тогтоомжийн дагуу экспортлогч улсад буцаах, эсхүл буцаах үүргээ | 2025.01.01<br>2025.06.10 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | ахлах байцаагчид хүргүүлсэн.<br>Хуулийн зохицуулалтаар импортын барааны ариутгал, халдваргүйжүүлэлт, эмчилгээг гаалийн байгууллага нь хяналт тавих чиг үүргийг хүлээсэн тул гаалийн улсын байцаагчийн хяналтад зөвшөөрөгдсөн шавж устгалын бодисоор мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагын зөвлөмжөөр ариутгал, халдваргүйжүүлэлт, эмчилгээг хийлгүүлж, хяналт тавих саналыг оруулж өгсөн. | | биелүүлэхгүй бол хуульд заасны дагуу шилжүүлэн устгах арга хэмжээг авч ажиллах талаар 2 удаа чиглэл хүргүүлж ажилласан.<br>БНЭУ-ын элчин сайдын яамнаас тус цагаан будааг гаалийн хилээр нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэж өгөх тухай албан бичиг ирүүлснийг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх боломжтойг тайлбарлаж ажилласан.<br><br>-Замын-Үүд боомтоор 1 дүгээр сард 22 тн цагаан будаанаас МУ-ын хилээр нэвтрүүлэхийг хориглосон хорио цээртэй шавж болох Цагаан будааны шөвгөр хошуут цох /Sitophilus oryze L/ - 6ш илэрч, экспортлогч улсад буцаах талаар чиглэл өгсөн.<br>**Хүрсэн үр дүн:** Хилийн боомтод амьтан, ургамлын хорио цээртэй зүйл илэрсэн үед авах хариу арга хэмжээ оновчтой, тодорхой болсон. | | |
| 2. | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд хяналт тавих | Хэрэгжилт, гүйцэтгэлээр тоогоор | Ургамлын хорио цээрийн хяналтаар 876 аж ахуйн нэгжийн 57,7 мян.тн, 53,5 мян.доллар, 2952 төрлийн 4022,6 кг дээж, 5,8 мян.доллар, 5937 үзүүлэлтээр чанарын шаардлага хангаж, 1598 үзүүлэлтээр хорио цээрийн шаардлага хангаж, 40 дээж, 38 үзүүлэлтээр шаардлага хангаагүй байна.<br>Ургамлын хорио цээртэй зүйлсээс урьдчилан сэргийлэх, арга хэмжээ авах ажлын хүрээнд 2024.03.11-ний өдөр | 1.Хяналтын чиглэл бүрээр лабораторийн шинжилгээнд хамрагдсан барааны тоо хэмжээ, үзүүлэлтийн тайланг сар бүр нэгтгэн, удирдлагуудыг мэдээллээр хангаж ажиллана.<br><br>2.Лабораторийн шинжилгээгээр зөрөг буюу шаардлага хангаагүй гарсан барааны дүнд дүн | -Замын-Үүд боомтоор 2 дугаар сард 845.9 тн /хүнсний ногоо/ чинжүүний сорьцноос Хүнс, хөдөө аж ахуйн сайдын А-100 тоот тушаалын хавсралтад бүртгэгдсэн Монгол улсад хязгаарлагдмал тархалттай хөнөөлт шавж болох Хүлэмжийн цагаан далавчтан (Trialeurodes vaporariorum) 4 ширхэг /үхсэн/ илэрч, халдваргүйжүүлэлт хийж хилээр нэвтрүүлсэн.<br>- Цэцэг 34.9 тн, Башир цэцгийн дээжинд-Шүлхий хачиг, Удвал цэцгийн дээжинд-Хүлэмжийн цагаан далавчтан Сараана, Удвал, Башир, Сарнай цэцгийн дээжинд-Ургамлын бөөс, Удвал цэцгийн дээжинд-Цацаг | 2025.01.01<br>2025.06.10 | 95% |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Өгөөж гурил ХХК-ийн ОХУ-аас импортлосон хүнсний улаанбуудайнаас гадаад хорио цээртэй хөнөөлт шавж гурилын жижиг жуулгавч /Tribolium confusum duv/ үхсэн хэлбэрээр 4 ширхэг илэрсэн.<br>Хөдөө аж ахуйн корпораци ХХК-ийн ОХУ-аас импортолсон үрийн улаанбуудай нь цэвэршилт нь 93.14% буюу үрийн стандартын шаардлага хангаагүй.<br>ОХУ-аас БНХАУ-д ургамал, ургамлын гаралтай бараа бүтээгдэхүүнийг дамжуулан тээвэрлэх мэдэгдэлгүйгээр Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр өнгөрүүлж хууль зөрчсөн тохиолдол илэрсэн.<br>Зориулалтын бус тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн зөрчил 7, Импортын мэдэгдэлгүй улсын хилээр нэвтрүүлсэн 8, гадны бохирдолтой, чанар стандартыг шаардлага зөрчсөн 3 зөрчилд торгуулийн арга хэмжээг авч шийдвэрлэсэн.<br>Шаардлага хангаагүй үзүүлэлттэй бараанд | шинжилгээ хийж, шийдвэрлэлтэд хяналт тавьж, энэ чиглэлээр газар, хороодыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана. | далавчтан илэрсэн. Халдваргүйтгэл хийж нэвтрүүлсэн.<br>- Замын-Үүд боомтоор 3 дугаар сард 467.5 тн /хүнсний ногоо/ Цоо байцааны дээжинд Хүнс, хөдөө аж ахуйн сайдын А-100 тоот тушаалын хавсралтад бүртгэгдсэн Монгол улсад хязгаарлагдмал тархалттай хөнөөлт шавж болох байцааны бөөс--5 ш /амьд илэрч, 2219.7 тн /хүнсний ногоо/ Цоо байцааны дээжинд Цацаг далавчтан--3 ш /үхсэн/ илэрч, Цоо байцааны дээжинд Цацаг далавчтан-4 ш /амьд/ илэрч, 14 тн цэцгэнд Удвал цэцгийн дээжинд Цацаг далавчтан -2ш /үхсэн/ илэрч халдваргүйжүүлэлт хийж хилээр нэвтрүүлсэн.<br>- Алтанбулаг боомтоор 3 дугаар сард 40 тн гичийн үрэнд дотоод хорио цээртэй хачиг илэрч, ариутгал халдваргүйтгэл хийж нэвтрүүлсэн.<br>**Хүрсэн үр дүн:** МУ-д импортлогдож буй ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хийгдэж буй лабораторийн шинжилгээт хяналтын үр дүнг баталгаажуулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | гаалийн улсын байцаагчийн эрх үүргийн хүрээнд холбогдох хуулийн дагуу шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. | | | | |
| 3. | Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл, экспортлогч улсын мал эмнэлэг, ариун цэвэр, ургамлын хорио цээрийн гэрчилгээг үндэслэн импортын гэрчилгээ олгох үйл ажиллагаанд хяналт тавих | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Импортын гэрчилгээ олголтод хууль, тогтоомжийн хүрээнд хяналт тавьж, гэрчилгээг цахимжуулах ажилд гэрчилгээнд тусгагдах мэдээллийг боловсруулж ажлын хэсэгт саналын хүргүүлсэн.<br>Ургамлын хорио цээрийн хяналтаар 254 аж ахуйн нэгж, 20 иргэний 7,2 мян.тн барааны, 140 экспортын гэрчилгээ, 1,3 сая төгрөгийн хураамжийн экспортын гэрчилгээ, 2 иргэн, 898 аж ахуйн нэгжийн 629,0 мян.тн, 24293618 ширхэг, 3097 м3 барааны, 1683 импортын гэрчилгээ, 16,8 сая төгрөгийн хураамж, 288 иргэн, 20 аж ахуйн нэгжийн 10,0 мян.тн, 4183131 ширхэг, 313 импортын мэдэгдэл, 3130,0 мянган төгрөгийн хураамж, 81 иргэний 1,7 тн, 81 дамжин өнгөрүүлэх мэдэгдэл, | 1.Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагааны талаар чиглэл, зааврыг хүргүүлж ажиллана.<br><br>2.Импортын гэрчилгээ олголтыг хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавих, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.<br><br>3.Харьяа гаалийн газар, хороодоос мал, амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд цахимаар олгох "Импортын гэрчилгээ"-г боловсронгуй болгож, хяналт, шалгалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх чиглэлээр Мэдээллийн | 1.Гаалийн ерөнхий газраас Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 97, импортын мэдэгдэл 509, дамжуулан тээвэрлэх мэдэгдэл 140, БНХАУ-д гурил экспортлох гэрчилгээ 82,<br>Гаалийн харьяа газар, хороодоор авч үзвэл<br>УБГГ: Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 429, мод, модон материалд 137, БНХАУ-д экспортлох хивэгийн гэрчилгээ 54, импортын мэдэгдэл 1461,<br>ДаГГ: Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 5, БНХАУ-д экспортлох хивэгийн гэрчилгээ 110, импортын мэдэгдэл 14,<br>ДоГГ: Ургамлын эрүүл ахуйн гэрчилгээ 2, мод, модон материал 2, импортын мэдэгдэл 12,<br>БөГГ: Импортын мэдэгдэл 142,<br>ЗаГГ: Импортын мэдэгдэл 16,<br>ОрГГ: Импортын мэдэгдэл 3,<br>СэГГ: Импортын мэдэгдэл 10,<br>ЗүГГ: Мод, модон материал 6,<br>УвГГ: Мод, модон материал 65, импортын мэдэгдэл 126 тус тус олгоход мэргэжлийн удирдлагаар хангасан.<br><br>Ургамал хамгааллын газартай 2025.01.15, 2025.01.22, 2025.02.26-ны өдрүүдэд 3 удаагийн уулзалт хийж, хурлын шийдвэрийг гаргаж, 2025.03.01-ний өдрөөс Ургамал | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 810.0 мян. төгрөгийг тус тус бүрдүүлсэн. | технологийн газартай хамтран ажиллана. | хамгааллын газар гэрчилгээ, мэдэгдлийг хүлээлгэн өгсөн.<br><br>2.Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан өнгөрүүлэх мэдэгдлийг баталгаажуулах албан тушаалтны гарын үсэг, тамганы дардас, гэрчилгээ мэдэгдлийн загварыг Хорио цээрийн хэлтсээс харьяа гаалийн газар хороодод 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 02-1.2/1241 тоот албан бичгээр хүргүүлсэн.<br>**Хүрсэн үр дүн:**<br>Хорио цээрийн цахим системээс Импортын гэрчилгээг олгодог болсноор Харьяа гаалийн газар, хороодын мал, амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд хяналт тавих үйл ажиллагаанд хяналт тавих боломжтой болсон. | | |
| **Зорилт 2 Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | | | |
| 4. | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлсэн байдал | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндэрч Засгийн газраас өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбогдуулан улсын хилээр нэвтрүүлэх малын өвс, тэжээлийн эрдсэлийн зөвшөөрөгдсөн шалгуурт 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдрийг хүртэл түр хугацаанд шилжүүлэ, лабораторийн шинжилгээт хяналтаас чөлөөлж, гадаад | 1. Хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан дүн шинжилгээ хийж, эрсдэлийн шалгуурыг тодорхой болгох зорилгоор Эрсдэлийн удирдлагын хэлтэстэй хамтран ажиллана.<br><br>2. Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд эрсдэлийн дүн | 1. Азийн хөгжлийн банкнаас “Ургамал, малын эрүүл ахуй, хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэрэгслийг сайжруулах төсөл”-ийг хэрэгжүүлэх Гаалийн ерөнхий газрын даргын А/115 дугаар тушаалаар ажлын хэсэг шинэчлэн байгуулагдан хорио цээрийн хяналтын чиглэлээр 7 дэд модулийн хөгжүүлэлтийг эцэслэсэн. Шинээр болон шинэчлэн, хөгжүүлэлт модуль тус бүр дээр хийгдэн төслийн гүйцэтгэл 87%-ийн гүйцэтгэлтэй ажилласан. Үүнд:<br><br>-Зорчигчийн хувийн хэрэглээний эмийн бүртгэл | 2025.01.01<br>2025.06.10 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | худалдааг хөнгөвчлөх чиглэлээр ажиллаж байна.<br>Эрсдэлийн удирдлагын хэлтэст эрсдэлийн шалгуур үзүүлэлтийг ургамлын хорио цээрийн хяналтыг чиглэлээр боловсруулан гаргаж гаргаж өгсөн.<br>Хорио цээрийн гэрчилгээ, мэдэгдэл Хүнс хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад шилжиж буйтай холбогдуулан 2024 оны 03 дугаар сарын 22-ны тус яамтай хамтарсан ажлын хэсэг байгуулагдсан. Хорио цээрийн хэлтсээс холбогдох баримт бичгийн жагсаалт, гэрчилгээ, мэдэгдлийн загварыг яамд хүргүүлж, бусад шаардлагатай мэдээллийг өгч ажилласан. | шинжилгээг хийж, хяналтаас чөлөөлөх саналыг боловсруулна.<br><br>3. Гадаад худалдаа эрхлэгчдэд хууль тогтоомжийг сурталчлах, зохион байгуулах чиглэлээр Олон нийттэй харьцах албатай хамтран байгууллагын вэб хуудсаар зөвлөмж, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна.<br><br>4.Монгол Улс, БНСУ хоорондын Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг хэрэгжүүлэх зорилгоор Амьтан, ургамлын эрүүл ахуйн арга хэмжээ (SPS), Худалдааны саат тодгорыг арилгах (TBT) хэлэлцээрүүдийн ээлжит хэлэлцээнд оролцож, холбогдох саналыг өгч ажиллана.<br><br>5. Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Ургамал, малын эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сайжруулах нь” | - Цацрагийн бүртгэл,<br><br>-Хорио цээрийн үйл ажиллагааны заавар,<br><br>-Хэрэглэгчийн удирдлагын модулиудын бүртгэлийн системийг цахимд нэвтрүүлэх,туршилтын тест<br><br>- Сэрэмжүүлэг мэдэгдэл<br><br>- Гэрийн тэжээвэр амьтны бүртгэл<br><br>- Олон улсын хөл хориот халдварт өвчний бүс нутгийн бүртгэлийг CAIS-ийн баазтай холбох ажлыг хийж хорио цээрийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн.<br><br>2. Монгол Улс, БНСУ-тай байгуулах ЭЗТХ-ийн 5 дугаар шатны хэлэлцээний бэлтгэл ажлыг хангах зорилгоор "Эдийн засгийн хамтын ажиллагаа" бүлэгтэй 2025 оны 2 дугаар сарын 21-нд уулзалт зохион байгуулж, хийх асуудлуудын саналыг боловсруулан ажилласан.<br>**Хүрсэн үр дүн:** Харьяа гаалийн газар хороодын байцаагчдыг мэргэжил, арга зүйгээр хангаж, мэдээллийн дата цуглуулах нөхцөл бололцоо бүрдсэн. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | төслийн хүрээнд хэрэгжүүлж буй “Хилийн хяналт удирдлагын систем”-ийн хөгжүүлэлтийг кодчилол, хөгжүүлэлт, суурилуулах, бета тест, сургалт хийх, гарын авлага бэлтгэх, хүлээлгэн өгөх тест нэвтрүүлэлт гэх мэт үе шатуудаар дуусгасан байна. | | | |
| 5. | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалт хийсэн байдал | Бараа, тээврийн хэрэгсэл, зорчигчийн тоо, өссөн буурсан хувь | Экспортын хяналт шалгалт: ургамлын хорио цээрийн хяналтын чиглэлээр нийт 92 аж ахуйн нэгж, 57 иргэний бараа экспортолсоноос мэдүүлэгээр 336, ангилалтын тоо хэмжээгээр 33,7 мян.тн, 1 мэдүүлэгээр 778 литр, 7 мэдүүлэгээр 18800 ширхэг бараа экспортлогдсон.<br>Барааны цэвэр жин 34,0 мян.тн, бохир жин 34,1 мян.тн, 33,9 мян.доллар байна.<br>Импортын хяналт шалгалт:<br>Ургамлын хорио цээрийн хяналтын чиглэлээр нийт 899 аж ахуйн нэгж, 187 иргэний бараа импортолсоноос | 1.Улсын хилээр нэвтрүүлж буй хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналт, шалгалт хийх ажлыг зохион байгуулах, харьяа газар, хороодыг мэргэжлийн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллана.<br><br>2.Хяналт, шалгалтын үйл ажиллагаа, тайлан мэдээнд дүн шинжилгээ хийж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. | Ургамлын хорио цээрийн хяналтын чиглэлээр нийт 3617 аж ахуйн нэгж, 24 иргэний бараа бүтээгдэхүүн экспортолсноос 3685 мэдүүлгээр, ангилалтын тоо хэмжээгээр 102,845,6 тн, 4 мэдүүлгээр 45 ширхэг бараа экспортлогдсон.<br><br>Ургамлын гаралтай бараа бүтээгдэхүүний цэвэр жин 103,023,5тн, бохир жин 103,630,2 тн, 221,070,1 сая.долларын үнийн дүнтэй байна.<br><br>Ургамлын хорио цээрийн хяналтын чиглэлээр нийт 4873 аж ахуйн нэгж, 6 иргэний бараа импортолсноос 5351 мэдүүлгээр цэвэр жингээр 145,938,9 мян.тн, бохир жингээр 149,434,1 мян. тн бараа импортлогдсон.<br><br>Ургамлын хорио цээрийн хяналтаар 166 аж ахуйн нэгж, 3 иргэний 15201,7 тн бараанд 1184 ш экспортын гэрчилгээ олгож, 18.1 сая төгрөгийн | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | мэдүүлэгээр 1079, ангилалтын тоо хэмжээгээр 895,9 мян.тн, 5 мэдүүлгээр 16538,4 литр, 69 мэдүүлэгээр 1106340 ширхэг, 1 мэдүүлэгээр 8,7м2, 17 мэдүүлэгээр 3108374 м3, 1 мэдүүлэгээр 220 хос бараа импортлогдсон.<br>Барааны цэвэр жин 767,2 мян.тн, бохир жин 785,1 мян.тн, 582,8 мян.доллар байна. | 3.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтад хамаарагдаг барааны 47 төрлийн заавры эцэслэн боловсруулан, баталгаажуулж, цахимаар ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.<br><br>4. БТКУС-ын 21 дүгээр бүлэг, 2106 (бусад газарт заагдаагүй хүнсний бүтээгдэхүүн) зүйлд хамаарах эрүүл мэндийн нэмэлт бүтээгдэхүүн, хүнсний нэмэлт зэрэг барааны гаалийн мэдүүлэгт дүн шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулна.<br><br>5. Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналт, шалгалтын үр дүнг сайжруулах зорилгоор холбогдох яам, агентлагаас зохион байгуулсан уулзалт, хэлэлцүүлэг, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллана.<br><br>6.Батлагдсан төлөвлөгөөний дагуу харьяа гаалийн газар, | хураамжийг улсын төсөвт төвлөрүүлж, 4239 аж ахуйн нэгжийн 83.779,8 тн бараанд 4223 импортын гэрчилгээ, 42,2 сая төгрөгийн хураамж, 293 аж ахуйн нэгжийн 2597,2тн 19643355ш бараанд 293 импортын мэдэгдэл олгож, 2,9 сая төгрөгийн хураамж, 18 аж ахуйн нэгжийн 17,5 мян.тн, 18 дамжин өнгөрүүлэх мэдэгдэл олгож, 180.0 мян. төгрөгийг тус тус улсын төсөвт төвлөрүүлсэн байна.<br><br>Ургамлын хорио цээрийн хяналтаар 2572 аж ахуйн нэгжийн 56.829.6мян.тн, 20,7сая.доллар, 1288 нэр төрлийн бараанаас 12,415.7кг шинжилгээнд хамруулж, 12265 чанар аюулгүй байдлын үзүүлэлт болон 8950 хорио цээрийн үзүүлэлтээр шаардлага хангаж, 50 дээжинд лабораторийн шинжилгээний дүнгээр шаардлага хангаагүй гарсан байна.<br><br>**Хүрсэн үр дүн:** Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд хийгдэх хорио цээрийн хяналтад дүн шинжилгээ хийж, статистик мэдээг нэгтгэдэг болсон. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | хороодын улсын байцаагчдад сургалт зохион байгуулна. | | | |
| 6. | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | 2023 оны хувийн ашиг сонирхолын мэдүүлгээ цаг хугацаанд нь үнэн зөв мэдүүлж, авлигатай холбоотой ил тод байдлыг бүрэн хангаж ажилласан.<br>2023 оны санхүүгийн тайлан, архивыг экспорын гэрчилгээ, импортын мэдэгдэл тус бүрээр товъёог хийн бэлтгэж архивт хүлээлгэн өгсөн.<br>Ургамлын хорио цээрийн хяналтын чиглэлээр 7 хоног бүрт танилцуулга бэлтгэн товч мэдээллийг гаргаж удирдлагыг мэдээллээр хангаж ажилласан.<br>Бүтэц чиг үүрэг шинэчлэн батлахтай холбогдуулан гаалийн ерөнхий газар, бүтцийн нэгж газар хороодын ургамлын хорио цээрийн хяналт хариуцсан гаалийн улсын байцаагч нарын албан тушаалын тодорхойлолтод нэмэлт | 1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналттай холбоотой эрх зүйн акт, бодлогын баримт бичгийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулна.<br><br>2.”Сангийн сайдын шийдвэр, өгсөн үүрэг даалгаврын биелэлт”, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт” зэрэг холбогдох тогтоол, шийдвэрийн хорио цээрийн хяналттай холбоотой заалтын 2024 оны эхний хагас жилийн тайланг гаргана. | 1.Тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэд технологийг нэвтрүүлж, ухаалаг технологид суурилсан газар тариаланг хөгжүүлэх, хөрсний үржил шимийг хамгаалж, сайжруулах зорилгоор “Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян”-ыг 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай өрнүүлэхээр шийдвэрлэсэн Монгол Улсын Засгийн газрын 47 дугаар тогтоол батлагдсан. Энэхүү тогтоолыг ГЕГ-ын удирдлагаас Хяналт бүрдүүлэлтийн газар, Эрсдэлийн удирдлагын хэлтэс, Хорио цээрийн хэлтэст “Хүнсний хувьсгал, цагаан алт хөтөлбөртэй уялдуулж зохион байгуулалтын арга хэмжээг авч, хэрэгжилтийг хангаж ажиллах” чиглэл өгсөн. Энэ ажлын хүрээнд “Цагаан алт” үндэсний хөдөлгөөний хүрээнд Улсын Их Хурлаас батлагдсан “Малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай” 63 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах эрчимжүүлэх ажлын хүрээнд Гаалийн байгууллагаас сүүлийн 3 жилд /2022-2024 онд/ экспортлогдсон малын гаралтай ноолуур, ноос, адууны арьс, үхэр, хонь, ямааны боловсруулсан арьс, дэл, сүүл, малын яс, малын өөхөн тос зэрэг нийт 11 төрлийн бүтээгдэхүүний экспортын судалгааг гаргаж нэгтгэн хэлтсийн удирдлагад танилцуулсан. | 2025.01.01<br>2025.06.10 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | саналыг тусган ажилласан.<br><br>2024 оны 1 дүгээр улирлын бичмэл тайланг гарган үнэлүүлсэн.<br><br>Тайлант хугацаанд 48 албан хүсэлт, 3 гомдол мэдээлэл хүлээн авч, 42 албан бичиг, 3 гомдлыг шийдвэрлэсэн. | | Засгийн газрын 2003 оны 173 дугаар тогтоолын хавсралт "Ургамлын үр, үрслэг, суулгац, амьтан, түүний үр, хөврөл үр, түүхий мах, дайвар бүтээгдэхүүн болон бичил биетний өсгөвөр, эмгэгт материалын дээжийг улсын хилээр нэвтрүүлэх боомтуудын жагсаалт", "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт, шалгалт хийх журам", "Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнд экспорт, импортын гэрчилгээ олгох журам"-ын төслүүдийг боловсруулсан.<br><br>**Хүрсэн үр дүн:** Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд хийгдэх хорио цээрийн хяналтын эрх зүйн зохицуулалт тодорхой болсон. | | |
| 7. | Үүрэг даалгаврын биелэлт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Дээд шатны удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр биелэлтийг хангаж, удирдлагад биелэлтийг тайлагнасан. | 1.Хэлтсийн ажлын мэдээг 7 хоног, сар, жилээр төлөвлөн тайлагнаж ажиллана.<br><br>2.СЭРП программын “Үүрэг даалгавар” цэс дээр байршуулсан хугацаатай үүрэг даалгаврын биелэлтийг хангуулж ажиллана.<br><br>3. Өргөдөл, гомдлыг хугацаанд нь хуулийн хүрээнд шийдвэрлэнэ. | -Бичиг хэрэг: Ирсэн бичиг, ирсэн дотоод зурвас: ГЕГ-ын бүтцийн нэгжийн газар, хэлтэс, дэргэдэх байгууллагаас 4 дотоод зурвас, харъяа Гаалийн газар, хороо болон бусад байгууллагаас 2 албан бичиг, яамд, агентлаг, аж ахуй нэгж, иргэдээс 37 албан бичгийг тус тус хүлээн авч шийдвэрлэсэн.<br>Явсан бичиг, явсан дотоод зурвас: ГЕГ-ын бүтцийн нэгжийн газар, хэлтэс, дэргэдэх байгууллагад 4 дотоод зурвас, Гаалийн газар, хороо болон бусад байгууллагад 5 албан бичиг, БНХАУ-ын Гаалийн ерөнхий газар, яамд, агентлаг, аж ахуй нэгж, иргэдээс 9 албан бичгийг тус тус хүргүүлж хамтран ажилласан.<br>**Хүрсэн үр дүн:** Үүрэг даалгавар биелэгдсэн | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 8. | Ажлын цаг ашиглалт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Эхний хагас жилийн байдлаар ажлаас тасалсан өдөр байхгүй, ажлын цаг ашиглалт сайн хөдөлмөрийн бүтээмж өндөр ажилласан. | 1.Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалтад хяналт тавьж, тайлагнана. | Тайлангийн хугацаанд ажил тасалсан, хоцорсон удаагүй.<br><br>Ажлын цаг ашиглалт 100% | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |
| 9. | Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт | Хэрэгжилт, гүйцэтгэлээр | Буудайн гурилын импортыг татвараас чөлөөлөх ажлын хүрээнд Байгаль орчин, Хүнс хөдөө аж ахуй байнгын хороонд ГЕГ-ын дэд дарга ажлын хэсгийн гишүүнээр ажилласан.<br>ГЕГ-ын дэд даргад буудайн гурилын экспорт, импортын мэдээ, МУ-ын хэмжээнд хэрэгжиж буй холбогдох хууль тогтоомжийн заалтын талаар мэдээ мэдээллийг гарган өгч ажилласан.<br>Тус байнгын хороонд "Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль"-ийг шинэчилсэн найруулгыг УИХ-д өргөн барих ажлын хэсгийн гишүүнээр ажилласан.<br>Цаг үеийн шинжтэй холбоотой мэдээ, мэдээллийг экспортлогч, импортлогч аж ахуй нэгж байгууллагуудад | 1.ЗББНДБ болон харьяа гаалийн газар, хороодтой хорио цээрийн хяналтын үйл ажиллагааг уялдуулж ажиллана.<br><br>2.МУ-ын УИХ-ын захирамж, холбогдох тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хэсгүүдэд ажиллана.<br><br>3.Цаг үеийн шинжтэй бусад арга хэмжээний хүрээнд төрийн болон төрийн бус болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллана. | Монгол Улсын Шадар сайдын тушаалаар байгуулагдсан Пестицидийн дэд ажлын хэсгийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн хурлаар эрдэмтдийн зөвлөлөөс гаргасан Ерөнхий төлөвлөгөөг танилцуулж санал авсан. Тус хурлын шийдвэрээр яамд, агентлаг, холбогдох байгууллагууд ерөнхий төлөвлөгөөнд багтсан нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж ирүүлэхээр болсоны дагуу саналыг боловсруулж хэлтсийн удирдлагад танилцуулсан.<br>- Сургалт, зөвлөгөөн:<br> ГЕГ-ын Хорио цээрийн хэлтсээс ХААИС-ийн Мал аж ахуй биотехнологийн сургуулийн 3 дугаар курсийн оюутнуудад Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлийн хууль, тогтоомж, хяналт, шалгалтын талаар сургалтыг зохион байгуулсан.<br>БӨГГ-ын Ментор шип хөтөлбарийн хүрээнд "Ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хорио цээртэй зүйл илэрсэн тохиолдолд авах хариу арга хэмжээ" сэдвээр цахим сургалт орсон.<br>**Хүрсэн үр дүн:** Төрийн болон төрийн бус байгууллагуудтай мэдээлэл | 2025.01.01<br>2025.06.10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зөвлөгөө мэдээлэл өгч ажиллав. | | солилцоо сайжирч, төлөвлөгөөний төсөл хэрэгжиж эхэлсэн. | | |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | | | |
| 10. | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | Хэрэгжилт гүйцэтгэлээр | ”Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-д санал өгч ажилласан.<br>Хэлтсийн удирдлагаас өгөгдсөн үүргийн дагуу УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд боловсруулан тайлагнаж ажилласан. | 1.Хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын чиглэлийн хууль тогтоомжийн биелэлтийг хангуулж ажиллан, илэрсэн зөрчил дутагдалд дүн шинжилгээ хийнэ.<br>2.ГЕГ-ын даргын 2019 оны 275 дугаар тушаалын хавсралтаар баталсан ”Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ыг шинэчлэхэд хорио цээрийн чиглэлэр саналыг өгч ажиллана.<br>3. Хорио цээрийн чиглэлээр хөрш зэргэлдээ болон бусад улсын мэргэжлийн байгууллагатай санамж бичиг, протоколыг байгуулахад санал өгч ажиллана.<br>3. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан ЗГ-ын тогтоолоор | Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар батлагдсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”-ын шинэчилсэн төсөлд санал боловсруулан тогтоосон хугацаанд өгсөн.<br>Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн тухай хуульд өөрчлөлт орсонтой холбогдуулан МУ-ын ЗГ-ын 173 дугаар тогтоолын1,2,3 дугаар хавсралтуудыг шинэчлэн төслийг боловсруулсан.<br>Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх хэсэгт заасан амьтны гоц халдварт өвчин болон ургамлын хорио цээртэй хөнөөлт организм улсын хилээр нэвтрэн тархах эрсдэл үүссэн болон үүсч болзошгүй нөхцөл байдал бүрдсэн үед баримтлах нийтлэг журам /дэглэм/-ийг боловсруулан ажиллаж байна.<br>2025 оны 05 дугаар сарын 28- ны өдөр Хорио цээрийн цахим системээс “Импортын гэрчилгээ”-г олгох болсонтой холбогдуулан Тэмдэгтийн хураамж авах, төлбөр, тооцоог цахим сувгуудыг ашиглан хялбараар төлөх гарцуудыг нээх асуудлын хүрээнд | 2025.01.01<br>2025.06.10 | 95% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | батлуулах 4 журам, зааврын төслийг боловсруулах.<br>4. Амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэх үеийн хорио цээрийн хяналт, шалгалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтын дагуу “Амьтан, ургамал, түүхий эд, бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавих тусгай шаардлага, тээврийн хэрэгсэлд хийгдэх халдваргүйжүүлэлтийн журам”-ыг боловсруулж, батлуулна.<br>5.Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, боловсронгуй болгох чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллана. | Интерактив ХХК-ын төлөөлөл, МТГ болон СХОГ-ын дарга, улсын байцаагчидтай уулзалт зохион байгуулж шийдлийг танилцуулж шийдвэрлэсэн.<br>Хорио цээрийн цахим систем дэх Импортын мэдэгдэл бүртгэх, импортын гэрчилгээг цахимаар олгох модульд 3 удаа тест хийж сайжруулалтын саналуудыг боловсруулж өгсөн.<br>Импортын гэрчилгээний хүснэгтийг нөхөн бичих зааврыг боловсруулсан.<br>Гаалийн хорио цээрийн системийн хэмжээний 2025 оны 01 дүгээр сарын зөрчлийн мэдээг нэгтгэн дүн шинжилгээ хийсэн.<br>**Хүрсэн үр дүн:** Ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүнд хийгдэх хорио цээрийн хяналтын эрх зүйн зохицуулалт тодорхой болсон. | | |

**Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биел ий ху |

|  | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино, дунд хугацааны болон цахим сургалтад хамрагдах | Сургалтын тоогоор | Гаалийн ерөнхий газрын Сургалтын төвөөс зохион байгуулж буй Англи хэлтэй гаалийн улсын байцаагч хөтөлбөрт хамрагдаж байна. | 1 сургалтад хамрагдсан байна. | 1 сургалтад хамрагдсан байна. 2025 оны 4 дүгээр улиралд багтаан сургалтад хамрагдсан байна. | 2025.01.01<br>2025.06.10 | 50% |
| 2. | Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх | Хэрэгжилт гүйцэтгэлээр | Сангийн яамнаас зохион байгуулсан Худалдах авах ажиллагаа /АЗ/ сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн. | Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна. | Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.<br>Эрх зүйн мэдлэг сайжирсан. | 2025.01.01<br>2025.06.10 | 95% |

**ТАЙЛАН ГАРГАСАН:**

| | | |
|---|---|---|
| УРГАМЛЫН ХОРИО ЦЭЭРИЙН ХЯНАЛТ ХАРИУЦСАН ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ | Д.ГАНПҮРЭВ / .......................... / | 2025 . 06 . 10 |
| *( Албан тушаал )* | *( Нэр, гарын үсэг )* | *( Огноо )* |

## ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ Д.ГАНПҮРЭВИЙН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
Нэгжийн нэр: ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТЭС

### 1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо | Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал | Нийлбэр оноо | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| | Оноо | 60 хүртэл | 10 хүртэл | 70 хүртэл | |
| **Зорилт 1. Хууль ёсны худалдааг хөнгөвчлөх** | | | | | |
| 1 | Гадаад худалдааг хөнгөвчлөх хүрээнд хорио цээрийн хяналтад хамрагдах бараанд эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлэх | 59 | 8 | 67 | |
| **Зорилт 2. Хууль сахиулах, аюулгүй байдлыг хангах** | | | | | |
| 1 | Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах | 58 | 8 | 66 | |
| 2 | Бараа, тээврийн хэрэгсэлд тавих хорио цээр, эрүүл ахуй, чанарын тохирлын хяналтын хэрэгжилт | 59 | 8 | 67 | |
| 3 | Экспортын гэрчилгээ, импорт болон дамжуулан тээвэрлэх мэдэгдэл, экспортлогч улсын мал эмнэлэг, ариун цэвэр, ургамлын хорио цээрийн гэрчилгээг үндэслэн импортын гэрчилгээ олгох үйл ажиллагаанд хяналт тавих | 58 | 8 | 66 | |
| 4 | Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт | 58 | 9 | 67 | |
| 5 | Магадлан шинжилгээний үйл ажиллагаанд хяналт тавих | 59 | 8 | 67 | |
| **Зорилт 3. Ногоон хөгжлийг дэмжиж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх** | | | | | |
| 1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт | 58 | 9 | 67 | |
| 2 | Үүрэг даалгаврын биелэлт | 60 | 10 | 70 | |
| 3 | Үндсэн шалгуурт тусгагдаагүй цаг үеийн шинжтэй бусад ажлыг төлөвлөх | 60 | 10 | 70 | |
| 4 | Ажлын цаг ашиглалт | 60 | 10 | 70 | |

### 2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Нийт (15 хүртэл оноогоор) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Гаалийн хэргийн мэдлэг олгох сургалтад хамрагдах | 100 | 15 | |
| **Дундаж оноо:** | | | 15 | |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Нэгжийн даргын үнэлгээ)

| Д/д | Үзүүлэлт | Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо) | Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо |
|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 |
| 1 | Хандлага, ёс зүй | 7 | |
| 2 | Дүн шинжилгээ хийх | 6 | |
| 3 | Асуудал шийдвэрлэх | 7 | |
| 4 | Хариуцлагатай байдал | 6 | |
| 5 | Ажлын цаг ашиглалт | 7 | |
| **Дундаж оноо:** | | **6.6** | |

**4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ** (Хамт олны үнэлгээ)

| Д/д | Хандлага, ёс зүй, ур чадвар | Хамт олны үнэлгээ (0-8 оноо) |
|---|---|---|
| | 1 | 2 |
| 1 | Хандлага, ёс зүй | 8 |
| 2 | Багаар ажиллах | 8 |
| 3 | Харилцаа | 8 |
| **Дундаж оноо:** | | **8** |

**5. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1 | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт *(Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)* | 61.8 |
| 2 | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт | 15 |
| 3 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Нэгжийн даргын үнэлгээ)* | 6.6 |
| 4 | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ *(Хамт олны үнэлгээ)* | 8 |
| 5 | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт *(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | |
| **Нийт оноо =** (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур | | **91.4** |

| | |
|---|---|
| чадварын оноо *(Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)* )- Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо | |

***Үнэлгээ өгсөн:***

***Нэгжийн дарга:***

ХОРИО ЦЭЭРИЙН ХЭЛТСИЙН ДАРГА ........................................ (Г.БАТМӨНХ)

2025.06.10 ........................(огноо)

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:***

***Төрийн жинхэнэ албан хаагч:***

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ........................................ ............(Д.ГАНПҮРЭВ)

2025.06.10 ...........................(огноо)

***Үнэлгээг хянасан :***

***Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:***

ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ................................ (Г.ЭНХТАЙВАН)

2025.06.25 ........................... (огноо)

***Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:***

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ ................................ (Ө.ТЭГШЭЭ)

2025.06.25 ...................... (огноо)

***Үнэлгээг баталгаажуулсан:***

***Төсвийн шууд захирагч:***

ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА ................................ (Р.ОТГОНЖАРГАЛ)

2025.06.25 ....................................(огноо)